

ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН НОРМАТИВ,
ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО
**МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН
НОРМ БА ДҮРЭМ**

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН
БАРИЛГА, ЗАСВАРЫН АЖЛЫН ТӨСӨВ
БОДОХ ДҮРЭМ**

ЗЗБНБД- 81-013-18

Албан хэвлэл

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

Улаанбаатар хот
2018 он

ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН НОРМАТИВ,
ТЕХНИКИЙН БАРИМТ БИЧГИЙН ТОГТОЛЦОО

**МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН
НОРМ БА ДҮРЭМ**

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН
БАРИЛГА, ЗАСВАРЫН АЖЛЫН ТӨСӨВ
БОДОХ ДҮРЭМ**

ЗЗБНБД- 81-013-18

Албан хэвлэл

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

Улаанбаатар хот
2018 он

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны дугаар сарын-ны өдрийн дугаар тушаалаар батлав.

Боловсруулсан:

Монгол Улсын Зөвлөх инженер	Д.БААСАНХҮҮ
Монгол Улсын Зөвлөх инженер	Р.БАЛЖИР
Монгол Улсын Зөвлөх инженер, Тэргүүлэх төсөвчин	Д.ЭНХТУЯА
Монгол Улсын Зөвлөх инженер, Тэргүүлэх төсөвчин	Б.МИНЖБАДАМ
Монгол Улсын Зөвлөх инженер, Тэргүүлэх төсөвчин	Я.ЦЭНДСҮРЭН
Монгол Улсын Зөвлөх эдийн засагч, Тэргүүлэх төсөвчин	Ц.ЦЭРЭНДОРЖ
Монгол Улсын Мэргэшсэн инженер, Мэргэшсэн төсөвчин	С.БАТСҮХ
Монгол Улсын Тэргүүлэх төсөвчин	Л.БААСАНБАТ
Монгол Улсын Мэргэшсэн төсөвчин	С.БАТ-АМГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН НОРМ БА ДҮРЭМ

**АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН БАРИЛГА, ЗАСВАРЫН АЖЛЫН
ТӨСӨВ БОДОХ ДҮРЭМ**

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Энэ зааврын үндсэн зорилго Монгол Улсын хэмжээнд шинээр барих, шинэчлэх, өргөтгөх, засвар хийх авто зам, замын байгууламжийн өртгийг тооцоолж, төсөв бодох үйл ажиллагааг нэг мөр болгон журамлахад оршино.
2. Энэхүү дүрэм нь ажлын зураг, техникийн шаардлага, гэрээний бусад баримт бичгүүдийг үндэслэн Монгол Улсын холбогдох хууль, эрх зүйн актуудад нийцүүлэн, төсвийн суурь нормуудыг ашиглан авто зам, замын байгууламжийн ажлын төсөвт өртгийг тооцоолоход ашиглагдана.
3. Энэ зааврыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хийгдэх авто зам, замын байгууламжийн барилга, засварын бүхий л төрлийн ажлын төсвийн тооцоонд салбарын төрөл, хөрөнгийн эх үүсвэр, өмчийн хэлбэрийг үл харгалзан заавал мөрдөнө.
4. Энэхүү зааврыг ашиглан тооцоолсон төсвийг Улсын төсөв, замын сан, гадаадын төсөл, хөтөлбөр, хувийн болон гадаадын компаниудын хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүхий л төрлийн зам барилгын ажлын хөрөнгө оруулалт, санхүүжилт, эдийн засгийн үр өгөөжийг тогтоох, тендерийн сонгон шалгаруулалтад бэлтгэх, тендер шалгаруулалтыг зохион байгуулах үе, түүнчлэн зохих хууль, тогтоомжийн дагуу шууд гэрээгээр гүйцэтгэх ажлын сонгон шалгаруулалт зэрэгт хэрэглэнэ.
5. Төсөв бодох заавар нь :
 - Үндсэн хэсэг
 - Төсвийн тооцооны маягт ба хавсралтуудаас бүрдэнэ.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ҮНДСЭН ХЭСЭГ

1. АВТО ЗАМЫН САЛБАРЫН ҮНЭ БҮРДЭЛТИЙН СИСТЕМИЙН НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Авто замын салбарын үнэ бүрдэлтийн систем:
 - Зам, тээврийн сайдын 2016 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 187 дугаар тушаалаар батлагдсан “Авто зам барилгын үйлдвэрлэлийн жишиг норм”, “Төмөрбетон гүүр, хоолойн барилгын үйлдвэрлэлийн жишиг норм”, “Авто зам барилгын ажлын төсвийн жишиг норм”, “Төмөрбетон гүүр, хоолойн барилгын ажлын жишиг норм”-ууд;
 - 2015 онд хэвлэгдсэн Барилга засвар, цахилгаан угсралт, барилга, сантехникийн ажлын төсвийн суурь нормын эмхтгэлүүд;
 - “Барилгын бүтээц, ажлын төрлөөр төсвийн суурь норм, түүний хавсралтуудыг боловсруулах, хэрэглэх дүрэм” БНБД 81-10-02;
 - Зам барилгын ажлын өртгийг тодорхойлоход зайлшгүй шаардлагатай бусад норматив, баримт бичиг, эрх зүйн актуудаас бүрдэнэ.
- 1.2 Зам барилгын ажлын төсөв бодох **нормативын бааз** авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан нормативын баримт бичгүүдээс бүрдэнэ.
- 1.3 Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын батлан гаргасан төсвийн норм, үнэ, үнэлгээний эмхтгэлүүдийг **төсвийн норматив** гэнэ.
- 1.4 Авто зам, замын байгууламжийн барилга угсралтын ажлын нэгж хэмжигдэхүүнд ноогдох нийт нөөц (замын ажилчдын хөдөлмөр зарцуулалт, машин механизм, тоног төхөөрөмжийн ажиллах хугацаа, материал, хийц эдлэлийн хэрэгцээ, тээврийн зардал гэх мэт)-ийн тоо зардлын хэмжээг **төсвийн суурь норм** гэж нэрлэнэ. Төсвийн суурь нормын үндсэн зориулалт нь аливаа ажлыг гүйцэтгэхэд шаардагдах нийт нөөцийн нормативт тоо хэмжээг тогтоож, үүний үндсэн дээр тухайн ажлыг үнэлэхэд оршино.
- 1.5 Төсвийн суурь норм авто зам, замын байгууламжид хийгдэх ажлыг ердийн нөхцөлд, технологийн шат дамжлагаар гүйцэтгэх ажлын үе шатаар зохиогдсон байдаг. Хэрэв онцгой нөхцөлд барилга угсралтын ажил явуулах бол тухайн нормд тохируулга хийх бөгөөд илтгэлцүүрийн хэмжээ, ашиглах нөхцлийг төсвийн техникийн хэсэгт тодорхойлдог.
- 1.6 Авто замын салбарын үнийн бодлого нь авто зам, замын байгууламжийн аливаа ажлын төсөвт өртгийг бодитойгоор тооцоолох, ажиллах хүч, машин механизм, тоног төхөөрөмж, материал, бусад нөөцийг үр ашигтай ашиглах, зарцуулахад чиглэгдэнэ.
- 1.7 Төсөвт өртөг тооцоолох үндэслэл нь замын барилгын холбогдох ажлыг гүйцэтгэх төслийн баримт бичиг, ажлын тоо хэмжээ, тоног төхөөрөмж ба хийц эдлэлийн жагсаалт, материалын үнэ, орон нутгийн татвар, хураамжууд зэргийг багтаасан ажлын зураг төсөл, техникийн шаардлага, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа төсвийн норматив, үнэ бүрдлийн тогтолцооны баримт бичгүүд байна.
- 1.8 Зураг төсөл, техникийн шаардлага, бусад баримт бичгийг үндэслэн төсөв бодох зааврын дагуу тооцсон зам барилгын ажлыг гүйцэтгэх, ашиглалтад оруулахад шаардагдах нийт мөнгөн хөрөнгийн нийлбэрийг зам барилгын ажлын **нийт төсөвт өртөг** гэнэ.
- 1.9 Зам барилгын ажлын нийт төсөвт өртөг нь хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлох, гүйцэтгэгч байгууллагын гүйцэтгэсэн ажлын тооцоо хийх, материалын

тоо хэмжээ, машин цагийн хэрэгцээ, тээвэрлэх ачааны жинг тодорхойлох, түүнчлэн нэгдсэн төсөвт байгаа бусад ажлын зардлыг санхүүжүүлэх, гүйцэтгэгч, захиалагч байгууллагын тайлан тэнцэл зохиох, бизнес төлөвлөгөө хийх суурь тооцоо болно.

- 1.10 Зам барилгын ажлын нэгдсэн төсвийн дүн нь ашиглалтад оруулсан зам, замын байгууламжийн үндсэн хөрөнгийн өртгийг тогтоох үндэслэл болно.

2. АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН АЖЛЫН ТӨСӨВ БОДОХ АРГАЧЛАЛ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ТӨСВИЙН БАРИМТ БИЧГИЙН БҮТЭЦ

- 2.1 Авто зам, замын байгууламжийн ажлын төсөвт өртөг нь зах зээлийн үнийн тухайн үеийн түвшинд (тооцоо хийж буй тухайн цаг үеийн жишиг үнээр) тооцоологдсон байх ёстой. Харин замын барилгын ажлын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хийх үед ээлжит санхүүгийн жилд гүйцэтгэх ажлын төсөвт өртгийг үнийн индексийн харгалзах системийг ашиглан, зах зээлийн үнийн хэтийн түвшинд тодорхойлно.
- 2.2 Тухайн жил буюу “замын барилгын ажлын улирал”-д эсвэл жил дамнан үргэлжлэн хийгдэх замын барилгын ажлын төсөвт өртөгт тусгагдах ажилчдын цалингийн тариф, материал түүхий эдийн үнэ, автомашинаар тээвэрлэх ачааны тн.км-ын үнэ, машин механизм, тоног төхөөрөмжийн машин цагийн үнэлгээний өөрчлөлтийг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулсан индексээр өөрчлөн тооцно.
- 2.3 Хэрэв тухайлсан ямар нэгэн ажилбарын өртгийг тооцоолоход шаардлагатай норм, норматив, эрх зүйн акт байхгүй бол түүнтэй ижил төстэй ажлын үнэлгээг хэрэглэж болно. Ийм боломжгүй бол шаардлагатай норм, үнэлгээг нэмэлт болгон боловсруулж, батлуулан мөрдөнө.
- 2.4 Суурь үнийг ашиглан төсвийн тооцоо (тухайн үеийн болон хэтийн) хийх үед замын барилгын ажлын шууд зардлыг бүрдүүлэгч хэсгүүдэд (барилга угсралтын ажлын төрлөөр), эсхүл шууд зардлын дүн болон нийт төсөвт өртгийн дүнд индексийг ашиглаж болно.
- 2.5 Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүнээс эрх шилжүүлж авсан байгууллага нь замын барилгын ажилд хэрэглэх төрөл бүрийн материал, хийц, эдлэхүүний үнийн мэдээллийн санг бүрдүүлэх, баяжуулах, жил, улирал тутамд олон нийтэд мэдээлэх үүрэгтэй байна. Энэ нь үнэ тарифийн өөрчлөлтийн тооцоо хийх албан ёсны үндэслэл болно.
- 2.6 Замын барилгын аливаа ажлын төсвийн баримт бичиг нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- а) Объектын төсвийн тооцоо
- б) Барилга угсралтын ажлын төсвийн тооцоо
- в) Нэгдсэн төсвийн тооцоо
- г) Төсвийн тайлбар бичиг

- 2.7 Зам барилгын ажлын төсвийн тооцооны баримт бичгийг бүрдүүлэхдээ дараах үндсэн дэс дарааллыг баримтлана. Үүнд:

А. Бэлтгэл ажил:

- Зам, замын байгууламжийн зураг төсөл, техникийн шаардлага бусад бичиг баримттай (тайлбар бичиг, геологи, геодези, байгаль орчны тайлан г.м) танилцах, ажлын тоо хэмжээг шалгах;
- Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох суурь нормууд цуглуулах;

- Төсвийн суурь нормын ажлын нэр төрөл, хэмжих нэгжийг объектын зураг төсөл, техникийн шаардлагын дагуу төсөв бодох ажлын үе шат, төрөл зүйлийн жагсаалт гаргах, төсвийн суурь нормын үндэслэл (шифр)-ийг бичих;
- Суурь нормд байхгүй ажилбаруудын үнэлгээг ижил төстэй ажлаар, эсвэл шинээр тооцоолох;
- Суурь нормуудад байгаа итгэлцүүрүүдийг ямар ажилд, өөрөөр хэлбэл ажлын ямар онцлог нөхцөлд ашиглахыг тогтоож, тооцоонд ашиглах;
- Тухайн төсөв бодоход хэрэглэгдэх үнэ бүрдлийн талаарх төрийн захиргааны байгууллагын гаргасан шийдвэр, тогтоол, дүрэм журам, холбогдох баримт бичгүүдийг бүрдүүлэх;

Б. Төсвийн тооцоо хийх:

- Ажилчдын хөдөлмөр зарцуулалт, цалингийн тооцоо
- Инженер техникийн ажилтануудын (ИТА) цалингийн тооцоо
- Материал, эдлэлийн хэрэгцээ, хүндийн жингийн тооцоо
- Материалын зардлын тооцоо
- Материалын тээврийн зардлын тооцоо
- Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт (машин цаг)-ын зардлын тооцоо
- Нүүлгэн шилжүүлэх зардлын тооцоо
- Түр барилгын элэгдлийн тооцоо

В. Төсвийн тооцоог гүйцэтгэх:

- Объектын төсвийн тооцоо хийх;
- Барилга угсралтын ажлын төсвийн тооцоо хийх;
- Нэгдсэн төсвийн тооцоо хийх гэх мэт дарааллаар төсвийн баримт бичгийг бүрдүүлнэ.

3. ОБЪЕКТЫН ТӨСВИЙН ТООЦОО

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 3.1.1. Замын барилгын ажлыг гүйцэтгэхдээ талбай дээр гардаг материаллаг зардлаар (шууд зардлаар) объектын төсвийн тооцоог хийнэ.
- 3.1.2. Объектын төсвийн тооцоог зам барилгын аливаа ажлыг гүйцэтгэх анхан шатны үйлдвэрлэлийн нэгж, байгууллага хэрэглэх ба ерөнхий болон туслан гүйцэтгэгч байгууллагын хийх ажлын хэмжээг тодорхойлоход ашиглана.
- 3.1.3. Авто зам, замын байгууламжийн төсвийг тооцоолохдоо тухайн объектын зураг төсөлд тусгасан тоо хэмжээ, техникийн шаардлагад заасан технологийг үндэслэн, төсвийн тооцооны бүлэг тус бүрээр гүйцэтгэнэ.
- 3.1.4. Бүлэг нь дараах байдалтай байж болно. Үүнд:

А. Зам

- а) Түр байр ба аж ахуйн бэлтгэл ажил
- б) Замын трасс сэргээж, гадаслах
- в) Материалын шинжилгээний ажил
- г) Талбайн цэвэрлэгээ
- д) Карьер ба шороон орд
- е) Хөдөлгөөн өнгөрүүлэх
- ё) Далан ба ухмалын ажил
- ж) Суурийн дэвсгэр үе
- з) Хайрган хөвөө байгуулах
- и) Замын суурь үе
- й) Авто замын хашлага тавих
- к) Хучилтын ажил
- л) Ус зайлуулах энгийн байгууламж
- м) Явган хүний зам
- н) Замын тэмдэглэгээ
- о) Замын тоноглол
- е) Өрөмдлөгө тэсэлгээний ажил
- п) Материалын бэлтгэл
- р) Объектыг ашиглалтад оруулах
- с) Хог хаягдал цэвэрлэх
- т) Хот тосгоны авто зам

Б. Хиймэл байгууламж

- а) Зохион байгуулалтын бэлтгэл
- б) Барилгын талбайн бэлтгэл
- в) Гүүр, хоолойн материалын ба хийц бүтээцийн үйлдвэрлэлийн бэлтгэл ажил
- г) Гүүрийн тулгуурын суурь
- д) Захын болон завсрын тулгуур байгуулах
- е) Алгаслалын бүтээц байрлуулах ба байгуулах
- ё) Зорчих хэсэг байгуулах
- ж) Хэв гажилтын заадас байгуулах
- з) Урсгал залах далан байгуулах
- и) Далан сувгийн бэхэлгээ
- й) Төмөр бетон хоолойн барилга
- к) Арматур хүчитгэх
- л) Лабораторийн туршилт, шинжилгээ
- м) Объектыг ашиглалтад оруулах

3.1.5. Төсвийн тооцоон дахь шууд зардлыг тодорхойлоход авто зам, замын байгууламжийн барилга, засварын ажлын төсвийн суурь нормууд, тэдгээрийн хавсралтуудаас дараах үндсэн өгөгдлүүдийг ашиглана. Үүнд:

а. Ажлын хөдөлмөр зарцуулалт (хүн.цаг)-аливаа ажлыг гүйцэтгэх инженер техникийн ажилтан, замын барилгын ажилчин, барилгын машин механизмын машинч, механизмчины цалинг тодорхойлох үндсэн өгөгдөл

б. Зам барилгын машины ажиллах цаг–замын барилгын үе шатны ажлуудад ашиглагдах машин механизм, тоног төхөөрөмжийн хэрэгцээ (машин.цаг)

в. Материал ба хийц эдлэлийн зарцуулалт-материал ба хийц эдлэлийн орцын норм. (м3, м2, тн, у/м, кг, ш) зэрэг биет нэгжээр хэмжигдэнэ.

г. Материал, хийц эдлэлийн тээвэрлэлт ба нүүлгэн шилжүүлэх ажил–тээвэрлэлтийн зайнаас хамаарч авах тээврийн тариф. (тн.км)

д. Түр барилгын элэгдлийн хугацаа (жил, сар, цаг)

3.1.6. Объектын төсөвт өртөгт ажилчдын болон тээвэр, нүүлгэн шилжүүлэлт, машин ашиглалтын цалин, инженер техникийн ажилтнуудын цалингийн зардал, материалын зардал, машин механизм, тоног төхөөрөмжийн зардал, тээврийн зардал (материал тээвэрлэх болон нүүлгэх шилжүүлэх) зэрэг шууд зардлаас гадна цалингийн сангаас бодогдох нийгмийн даатгалын шимтгэл, нэмэгдэл цалин, багаж хэрэгслийн болон ажлын хувцасны элэгдэл, түр барилгын элэгдлийн зардлуудыг оруулж тооцно.

3.1.7. Төсвийн бүрдэл хэсгүүдийн тооцоог нэг бүрчлэн хийсний дараа объектын нэгдсэн тооцоог зам барилгын тодорхой ажил, эсвэлбүлэг ажлаар нь тооцож, нэгтгэнэ. Объектын төсвийг Маягт №3-8-ийн дагуу нэгтгэнэ.

3.1.8. Зөвхөн шууд зардлаар, өөрөөр хэлбэл барилга угсралтын ажлын өртгөөр тооцох төсөв тухайн ажил эрхлэж буй ИТА-уудын гарын авлага болох бөгөөд уг тооцоог ажлын төсөв гэж нэрлэж болно.

3.2. АЖИЛЧДЫН БОЛОН ИТА-ЫН ХӨДӨЛМӨР ЗАРЦУУЛАЛТ, ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

3.2.1. Ажилчдын хөдөлмөр зарцуулалт, цалингийн зардлын тооцоог Маягт №3-1-ийн дагуу тооцно.

3.2.2. Замын барилгын ажилчдын цалинг Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан цагийн тарифт цалингийн жишгийг баримтлан тогтооно. (Хавсралт 3-1)

3.2.3. Үйлдвэрлэлийн ИТА-ны цалинг ажилчдын үндсэн цалин, тээврийн жолоочийн цалин, машин механизмын операторчдын цалингийн нийлбэр дүнгээс 17,0 хувиар тооцно.

- 3.2.4. Замын барилгын ажилчдын нэмэгдэл цалингийн хэмжээг ажилчдын үндсэн цалин, тээврийн жолоочийн цалин, машин механизмын операторчдын цалин, нүүлгэн шилжүүлэх ажлын цалингийн нийлбэр дүнгээс 15,1 хувиас ихгүй байна.
- 3.2.5. Төсвийн норм зохиогдоогүй ажлуудад замын барилгын ажилчдын цалинг тооцоолох зорилгоор тарифын сүлжлийн итгэлцүүрийг ашиглан нэгж ажлын гүйцэтгэх салаа, хэсгийг бүрдүүлж буй ажилчдын зэргийг тодорхойлж, төсвийн тооцоонд ашиглана.

$$z = \frac{1 \times n_1 + 2 \times n_2 + 3 \times n_3 + 4 \times n_4 + 5 \times n_5 + 6 \times n_6}{n_1 + n_2 + n_3 + n_4 + n_5 + n_6}$$

Z - Ажилчдын дундаж зэрэг

n – Мэргэжлийн зэргийн цагийн норм / хүн.цаг /

3.3. ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫН МАТЕРИАЛ БОЛОН ТЭЭВРИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

- 3.3.1. Материал, тээврийн зардлын тооцоог гаргахын тулд ажлын зураг, техникийн шаардлагыг үндэслэн материалын хэрэгцээ, хүндийн жин (тээвэрлэх ачааны хэмжээ)-г тооцож гаргана. Материалын зардлыг тооцоог Маягт №3-3-ын дагуу тооцно.
- 3.3.2. Материалын тээврийн зардлын тооцоог Маягт №3-4-ын дагуу тооцно.
- 3.3.3. Төсвийн тооцоонд материалын зардлыг тухайн объектын ажлын зураг, техникийн шаардлага, ажлын тоо хэмжээг үндэслэсэн материал, хийц, эдлэхүүний (тн, м2, м3, у/м, кг, ш) замын барилгын ажилд шаардлагатай тоо хэмжээ ба материалын төрөл тус бүрт харгалзах зах зээлийн үнийг ашиглан тооцно.
- 3.3.4. Материалын тээврийн зардалд ачиж-буулгах ажлын зардлыг багтаасан байна. Материалыг тухайн бүс нутгийн зах зээлийн дундаж ханшаар үнэлж, төсвийн тооцоонд тусгана.
- 3.3.5. Материал нийлүүлэгч албан байгууллага ба хувь хүнд Гүйцэтгэгчээс төлөх НӨАТ-ыг төсвийн тооцооны шууд зардлын тооцоонд оруулахгүй.
- 3.3.6. Ижил төрлийн материалын үнийг төсвийн тооцоонд нэг үнээр тооцож оруулна.
- 3.3.7. Замын барилгын ажлын аливаа материалын үнийг ажил гүйцэтгэж байгаа бүс нутгийн зах зээлийн дунджаас өндөр үнээр төсвийн тооцоонд тусгахыг хориглоно.
- 3.3.8. Замын барилгын ажилд хэрэглэх материал, хийц, эдлэхүүний үнэ бүрдэлт дараах нийтлэг жишигтэй байна. Үүнд:

а) Импортын материал–ын үнэ дараах томъёогоор тодорхойлогдоно.

$$Y_{\text{имп}} = B * K + T3^1 + GT + H\theta AT + T3^2 + BH\theta H + T3^3 + BH$$

Энд: В- уг материалын импортын үнэ; К-валютыг төгрөгт шилжүүлэх илтгэлцүүр; T3¹- гадаад тээврийн зардал, энэ тээврийн зардлыг валютаар тооцоод төгрөгт шилжүүлж тооцно. GT-гаалийн татвар; HӨАТ- нэмэгдсэн өртгийн албан татвар; T3²-гаалийн татвар төлөх хилийн шалгах цэгээс төмөр зам, авто тээврийн цэг хүрэх зардал; BHӨН- бэлтгэн нийлүүлэгч байгууллагын нэмэгдэл. Энэ нь үйл ажиллагааны зардал ба ашгийн нэмэгдлээс бүрдэнэ. T3³-бэлтгэн нийлүүлэгчээс объект (бирж) хүртэл тээвэрлэх зардал бөгөөд энэ зардлыг бэлтгэн нийлүүлэгч тал хариуцна, BH- биржийн болон байгууллагын нэмэгдэл;

б) Эх орны үйлдвэрийн материал

Эх орны үйлдвэрийн материалын үнэ дараах томъёогоор тодорхойлогдоно.

$$Y_{\text{эх орон}} = BY + H\theta AT + BB + B3$$

BY- үйлдвэрийн үнэ; HӨАТ- нэмэгдсэн өртгийн албан татвар; BB- баримтын үнэ(падаан зэрэг нягтлангийн зардал), B3- буулгах зардал. Эх орны материалыг агуулахаар дамжуулахгүйгээр шууд объект дээр буулгана гэж тооцно.

а) Зам барилгын ажлыг гүйцэтгэгч байгууллагын өөрөө бэлтгэх материал

$$Y_{\text{өөрөө}} = BY + B3$$

BY-материал бэлтгэлийн үнэ. Тухайлбал суурийн буталсан чулуун материалыг бэлтгэх үнэд чулууг олборлох газрыг судалж тогтоох, ухаж, боловсруулалт хийх овоолох, ачиж буулгах, ажилчдын томилолтын зардал, хээрийн нэмэгдэл багтана. B3- буулгах зардал

- 3.3.9. Төсвийн тооцоог хялбарчлах зорилгоор материал, машин механизм, тоног төхөөрөмжийн хэрэгцээ, үнэ, тээврийн зардлын тооцоонд материалыг нэр тус бүрээр нь бүлэглэж оруулна. Зам барилгын ажилд ашиглагдах материал, хийц, тоноглол, эд хогшилын тээвэр, мөн машин механизм, тоног төхөөрөмжийн нүүлгэн шилжүүлэх зардлын тооцоонд ашиглах ачааны зэргийг Хавсралт 3-3 дагуу тооцно.
- 3.3.10. Ачааны зэргийг зарим зөвшөөрөгдөх тохиолдолд дараах хэлбэрээр хялбарчлан тооцож болно.
- а) Тээврийн хэрэгслийн даацанд хүртэл ачаалж болох ачаа буюу эвдэрч хэмхрэхгүй ачаа - I зэрэг
 - б) Тээврийн хэрэгслийн даацанд хүртэл ачаалж болохгүй ачаа буюу хагарч гэмтэх ачаа - II зэрэг
 - в) Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл хэрэглэх ачаа буюу тэсэрч, дэлбэрэх ачаа - III зэрэг
- 3.3.11. Тээврийн тарифыг тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан ачааны зэрэг, тээврийн зайнаас хамааруулан сонгоно. (Хавсралт 3-4,3-5)
- 3.3.12. Тээврийн жолоочийн цалингийн зардлын хэмжээг тооцохдоо тээврийн нийт зардлын дүнгээс 8.7 хувиар бодож төсөвт тусгах ба нэгдсэн төсвийн тооцоонд тээврийн зардлын дүнгээс хасна.

3.4. ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫН МАШИН МЕХАНИЗМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

- 3.4.1. Замын барилгын ажлын машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал нь тэдгээрийн зам барилгын ажил гүйцэтгэх үед ашиглах зардал (маш.цаг)-аар тодорхойлогдоно.
- 3.4.2. Замын барилгын ажлын машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлыг Маягт №3-5 дагуу тооцно.
- 3.4.3. Замын барилгын ажлын механизмын операторчидын цалинг машин механизмын нийт зардлын дүнгээс 8.7 хувиар бодож төсөвт тусгах ба нэгдсэн төсвийн тооцоонд машин механизмын зардлын дүнгээс хасна.
- 3.4.4. Төсвийн тооцоонд нэгж машин цагийн үнийг тодорхойлохдоо тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан “Замын машин механизмын ашиглалтын цагийн жишиг үнэ”-ийг баримтлана. (Хавсралт 3-6)
- 3.4.5. Машин механизм, тоног төхөөрөмжийн нэгж машин цагийн батлагдсан үнэлгээ байхгүй тохиолдолд ижил төрлийн машины жишиг үнээр үнэлнэ.
- 3.4.6. Гүйцэтгэгч байгууллага машин механизмын техникийн суурь өгөгдөл болон өөрийн өртөг, ашиглалтын үнийн тухай мэдээллийг цахим хэлбэрт оруулж, бүртгэлийг тогтмол хөтөлж байх ёстой.

3.5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

- 3.5.1. Замын барилгын ажил явагдаж байгаа замын дагууд машин механизм, тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэх ажлын зардлыг тухайн машин механизмын нэгж машин.цаг-ийн үнэд багтаан тооцсон байна.
- 3.5.2. Хүнд машин механизм, тоног төхөөрөмж, аж ахуйн тоноглол, эд хогшил зэргийг нэг цэгээс объект хүртэл эсхүл объект хооронд, зам барилгын ажилчдыг нэг цэгээс нөгөө цэгт нүүлгэн шилжүүлэх зардлыг Маягт №3-6 ба №3-7 дагуу тооцно.

- 3.5.3. Замын барилгын ажилчдын нүүлгэн шилжүүлэх зардлыг тооцохдоо нэг цэгээс нөгөөд шилжүүлэх тарифыг Зам тээврийн сайдын 2013 оны 162 дугаар тушаалыг үндэслэн тооцоолно.
- 3.5.4. Нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны цалингийн зардлын хэмжээг тооцохдоо нийт нүүлгэн шилжүүлэх зардлын 8.7 хувиар бодож төсөвт тусгах ба нэгдсэн төсвийн тооцоонд нүүлгэн шилжүүлэх зардлын дүнгээс хасна.

3.6. ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫН БАГАЖ ХЭРЭГСЭЛ, АЖЛЫН ТУСГАЙ ХУВЦАС, ТҮР БАРИЛГЫН ЭЛЭГДЛИЙН ТООЦОО

- 3.6.1. Замын барилгын ажилчдын хөдөлмөрийн багаж хэрэгсэл, ажлын хувцасны элэгдлийн зардлыг ажилчдын үндсэн цалингийн дүнгээс 11.1 хувиар тооцож төсөвт тусгана.
- 3.6.2. Ижил төрлийн түр барилгын элэгдлийг замын барилгын ажлын нийт төсөвт ижил элэгдлийн хувиар тооцно.
- 3.6.3. Ажлын төсвийн тооцоонд тусгах түр барилга байгууламжтай холбоотой шууд зардлыг зураг төсөл болон техникийн шаардлагын дагуу төсвийн суурь нормд үндэслэн, тусад нь төсвийн тооцоо хийж тогтооно.
- 3.6.4. Түр барилгын элэгдэл тооцох үнийг ажил гүйцэтгэж байгаа бүс нутгийн зах зээлийн дунджаас өндөр үнээр авч төсвийн тооцоонд тусгахыг хориглоно.
- 3.6.5. Түр барилгын элэгдлийн тооцоог хийхдээ дараах үндсэн зарчмыг баримтлана. Үүнд:
- а) Замын барилгын ажлын үед дахин давтан хэрэглэх боломжгүй түр барилга ашиглах тохиолдолд элэгдлийн зардал бодогдохгүй.
 - б) Түр барилгыг дахин давтан ашиглах боломжтой бол ашиглалтын норм, тухайн барилгын балансын үнэ, хэдэн удаа хэрэглэх эргэлтийг тооцож, элэгдлийн хувийг тогтоож, холбогдох зардлыг тооцно.

3.7. ЗАМЫН БАРИЛГЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ИТА, ЗАМЫН БАРИЛГЫН АЖИЛЧДЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ (НДШ)-ИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

- 3.7.1. Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 15.1 зүйлд заасны дагуу ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг замын барилгын ажилчдын цалин, нэмэгдэл цалин, талбайн инженер техникийн ажилтнуудын цалингийн нийлбэр буюу нийт цалингийн сангийн 11 хувиар тооцно. (Нийгмийн даатгалын хуулинд өөрчлөлт орсон тохиолдолд энэхүү хувь хэмжээ өөрчлөгдөнө)
- 3.7.2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоолын дагуу зам гүүрийн барилга, засвар арчлалтын ажил эрхэлдэг, түүнчлэн замын барилгын материалын үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүд “үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгал”-ын шимтгэлийг нийт цалингийн сангаас 3 хувиар тооцож объектын төсөвт тусгана.

4. БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ТӨСВИЙН ТООЦОО

4.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 4.1.1. Төсвийн энэхүү тооцоо нь замын барилгын ажил гүйцэтгэгч байгууллагын нийт өртөг буюу барилга угсралтын ажлын төсөвт өртгийг тооцоолоход зориулагдана.
- 4.1.2. Барилга угсралтын ажлын төсөв нь объектын төсвөөр тооцоолсон шууд зардлууд, удирдлагын зардал, ашиг, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардал, барилга угсралтын болон машин механизм, тоног төхөөрөмж, ажилчдын даатгалын шимтгэлүүд, ажилчдын хээрийн нэмэгдлээс бүрдэнэ.
- 4.1.3. Барилга угсралтын ажлын төсвийн тооцоог Маягт №4-1 дагуу тооцно.

4.2. УДИРДЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

- 4.2.1. Удирдлагын зардлын хэмжээг төсөвт тусгахдаа замын барилгын ажилчид ба инженер техникийн ажилтны цалингийн санг суурь болгон авна.
- 4.2.2. Удирдлагын зардлыг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2007 оны 187 дугаар тушаалын дагуу төсвийн тооцооны нийт цалингийн сангаас 63,5 хувиар тооцож, төсөвт тусгана.
- 4.2.3. Удирдлагын зардлын бүтэц, зардлыг бүрдүүлэгч зүйл анги тус бүрийн нийт зардалд эзлэх хувь хэмжээг Хүснэгт 4-1-т үзүүлэв.

Хүснэгт 4-1

Зардлын зүйл анги	Нийт зардалд эзлэх хувь хэмжээ (%)
Захиргаа аж ахуйн ажиллагсадын цалин	31.9
Захиргаа аж ахуйн ажиллагсадын НДШ	6.3
Шуудан холбооны зардал	5.7
Газрын төлбөр	1.7
Албан томилолтын зардал	1.4
Удирдлагын барилга байгууламжийн ашиглалтын зардал	23.5
Удирдах болон ИТА-ны үйлчилгээний авто машины зардал	11.8
Сургалтын зардал	0.9
Угаалга, ариун цэврийн зардал	3.0
Биет бус хөрөнгийн элэгдэл	0.4
Зөвөлгөө, мэдээлэл, аудитын зардал	3.3
Хэвлэн олшруулах техник хэрэгслийн ашиглалтын зардал	2.4
ТУЗ, хяналтын зөвлөл, бусад дээд байгууллагад төлөх шимтгэл	3.7
Бичиг хэрэг, техникийн ном, норм дүрэм худалдан авах болон архивын зардал	1.6
Банк болон бусад байгууллагад төлөх шимтгэл	1.7
Шинэ санаачлага, оновчтой саналыг хэрэгжүүлэх зардал	0.2
Тендертэй холбоотой зардал	0.5
Удирдлагын зардлын дүн	100

4.3. АШГИЙН ТООЦОО

- 4.3.1. Замын барилгын ажлын төсөвт ашиг нь ажил гүйцэтгэх үеийн байгууллагын нийт зардлыг нөхөх, үйлдвэрлэлийн баазыг бэхжүүлэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг үйл ажиллагааны хөрөнгө оруулалтад зарцуулагдана.
- 4.3.2. Ашиг нь замын барилгын бүтээгдэхүүний үнийн нормативын хэсэг бөгөөд ажлын өөрийн өртөгт хамаарахгүй.
- 4.3.3. Ашгийн хэмжээг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2007 оны 187 дугаар тушаалын дагуу төсвийн тооцооны нийт цалингийн сангаас 71,8 хувиар тооцож, төсөвт тусгана.
- 4.3.4. Ашгийн зүйл ангийн бүтэц, нийт ашигт зүйл анги тус бүрийн эзлэх хувь хэмжээг Хүснэгт 4-2-д үзүүлэв.

Хүснэгт 4-2	
Зардлын зүйл анги	Нийт зардалд эзлэх хувь хэмжээ (%)
Үндсэн хөрөнгийн засвар, шинэчлэлт	14.3
Эргэлтийн хөрөнгийн өсөлт	16.3
Ажилчид болон өндөр настанд үзүүлэх тэтгэвэр, тэтгэмж	2.1
Шагнал урамшуулал	2.7
Баяр ёслолын үйл ажиллагааны зардал	3.6
Мөрдөгдөж буй шийдвэрийн дагуу ажиллагсадад үзүүлсэн хөнгөлөлт	5
Мэргэжилтэн бэлтгэх зардал	12.5
Ажиллагсадын эрүүл мэндийг хамгаалах, амралт сувилалын зардал	0.5
Орлогын албан татвар	3.5
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	1.1
Байгууллагыг бэхжүүлэх зорилгоор урт хугацаатай зээл (лизинг)-ээр худалдан авсан машин механизм, тоног төхөөрөмжийн үндсэн төлбөр болон хүүгийн төлөлт	38.4
Ашгийн зардлын дүн	100

4.4. ТӨСӨВТ ТУСГАХ ДААТГАЛ БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

- 4.4.1. Төсвийн тооцоонд даатгалын зардлын хувь хэмжээг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2007 оны 187 дугаар тушаалын дагуу тусгана. Үүнд:
- а) Ажиллагсдын даатгалыг тухайн жил тутамд тогтоосон нэг хүний үнэлгээнээс 0.8 хувиар
- б) Барилга байгууламжийн даатгалыг объектын төсвийн шууд зардлын дүнгээс 0.4 хувиар
- в) Машин механизм, тоног төхөөрөмжийн даатгалыг зөвхөн тухайн объектод ажиллах машин механизм, тоног төхөөрөмжийн балансын үнийн 0.5 хувиар тус тус тооцно.

4.4.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардлын хувь хэмжээг шууд зардлын дүнгээс 2.5 хувиар тооцож төсөвт тусгана. Энэ зардал нь “Авто замын салбарын үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын иж бүрэн дүрэм”-ийн дагуу замын барилгын ажлын туршид хийгдэх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах үйл ажиллагааны зардал юм.

4.5. ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫН ТАЛБАЙД АЖИЛЧДАД ҮЙЛЧЛЭХ ЗАРДАЛ

4.5.1. Замын барилгын ажлын талбайд ажиллах ИТА, замчид, механизмчид, тээвэрчдэд үйлчлэх зардлыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2012 оны 48 дугаар тушаалын дагуу ажилласан өдөр тутамд төгрөгөөр тооцож төсөвт тусгана.

4.5.2. Төсөвт тусгах ажилчдын замын барилгын ажлын талбайд нийт зардлын хэмжээг үндсэн ажлын хөдөлмөр зарцуулалт (хүн.цаг), машин механизмын нийт маш.цаг, тээврийн зардалд тооцогддог хөдөлмөр зарцуулалт (хүн.цаг)-ийн нийлбэрийг ажлын нэг өдрийн үргэлжлэх хугацаа (7.97)-д хувааж, ноогдворыг нэг хүн.өдрийн хээрийн нэмэгдэл болох 7200 төгрөгөөр үржүүлж гаргана.

Нэг материалын тээврийн хөдөлмөр зарцуулалт (хүн.цаг)-ийг бодохдоо дараах томъёогоор бодно.

$$T_{хц} = \left[\frac{A_0 * H_x * X_3 * 1,22}{1,11} \right] : 60$$

A_0 – тухайн материалын тоо хэмжээ

H_x - тухайн материалын нэгж хүнд

X_3 – тухайн материалыг тээвэрлэх тээврийн зай

5. НЭГДСЭН ТӨСВИЙН ТООЦОО

5.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 5.1.1. Нэгдсэн төсвийн тооцоогоор авто зам, замын байгууламжийн нийт төсөвт өртгийн хэмжээг тодорхойлно. (Маягт №5-1) Нэгдсэн төсвийн тооцоонд үндэслэн бие даасан ажил бүрийн төсвийн нэгж үнийг тооцон гаргаж болно.
- 5.1.2. Нийт хөрөнгө оруулалтын хэмжээг Маягт №5-2-ын дагуу тодорхойлно. Хөрөнгө оруулалтын II, III бүлэгт хамаарах зардал, ажлын хөлсийг тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дангаараа болон бусад байгууллагатай хамтарч тусгайлан гаргасан шийдвэрээр тогтооно.

5.2. ТУСГАЙ ТӨРЛИЙН АЖИЛ БА ЗАРДЛЫН ТООЦОО

- 5.2.1. Төсвийн норм, нормативын баримт бичигт тусгаагүй бөгөөд хөрөнгө оруулалтад зайлшгүй оруулах шаардлагатай зардлыг тусгай төрлийн ажил буюу зардал гэнэ. Уг зардалд газрын төлбөр, авто замын зурваст орсон барилга, байгууламжийг нүүлгэн шилжүүлэх болон нөхөх төлбөр, засгийн газрын шийдвэрээр тогтоосон хөнгөлөлт, эсвэл нэмэлт төлбөртэй холбоотой зардал зэргийг багтаана.
- 5.2.2. Тусгай төрлийн ажил ба зардлын хэмжээг Монгол Улсын Газрын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Газрын төлбөрийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, Засгийн газар болон бусад субъектын баталсан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичгийг үндэслэн тогтооно.

5.3. ХАЙГУУЛ, ЗУРАГ ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

- 5.3.1. Авто зам, замын байгууламжийн хайгуул, зураг төслийн зардлыг тухайн үеийн мөрдөгдөж буй хүчин төгөлдөр тушаал шийдвэрийн дагуу тодорхойлно.
- 5.3.2. Инженерийн хайгуул, инженер-геологийн судалгаа, геодезийн ажлын зардал нь авто замын трассын хайгуул, судалгаа, трасс сонголтын үндсэн ажлууд болон тэдгээрийг гүйцэтгэхэд шаардагдах бэлтгэл ба дагалдах ажлуудын зардлыг, харин зураг төслийн зардал нь Монгол Улсын нутаг дэвсгэрт баригдах нийтийн зориулалттай авто зам, замын байгууламжийг төсөллөх, зураг төслийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын зардлыг тус тус хамаарна.

5.4. НЭГДСЭН ТӨСВИЙН ТООЦООНД ОРОХ ЗАРДЛЫН ТООЦОО

- 5.4.1. Замын барилгын ажлын явцад захиалагч, гүйцэтгэгч байгууллагын аль аль нь урьдчилан харах боломжгүй байсан нөхцөл байдлаас үүсэн гарч болох нэмэлт ажлыг “Магадлашгүй ажил” гэх бөгөөд уг ажлын төлбөрийг Сангийн сайд, Дэд бүтцийн хөгжлийн сайдын 1996 оны 406/406-р хамтарсан тушаалын дагуу шууд зардлын дүнгээс 2 хувиар тооцно. Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын явцад зайлшгүй хийх нэмэлт ажлыг магадлашгүй ажлын зардлаас санхүүжүүлнэ
- 5.4.2. Өдрөөр тооцох ажил (Day work). Зам, замын байгууламжийн зураг төсөл, ажлын тоо хэмжээ, техникийн шаардлагад “Өдрөөр тооцох ажил” тусгагдсан бол энэ тооцоог тусад нь бүлэг болгон, тооцоог хийж, Нэгдсэн төсвийн тооцоонд тусгана. Зам барилгын ажлын явцад гарсан бага хэмжээний нэмэлт ажлыг Зөвлөх компанийн зөвшөөрлөөр энэ зардлаас санхүүжүүлнэ.

-
- 5.4.3. Замын барилгын ажлын явцад зүйл 5.4.1-5.4.2-д заасан нэмэлт зардал бий болоогүй нөхцөлд нэгдсэн төсөвт тусгагдсан “Магадлашгүй ажил” болон “Өдрөөр тооцох ажил”-ын зардал Захиалагчид үлдэнэ.
 - 5.4.4. Техник, технологийн хяналтын (Зөвлөх үйлчилгээ) зардлыг тухайн төслийн шууд зардлын дүнгийн 5 хүртэлх хувиар тооцно.
 - 5.4.5. Захиалагчийн хяналтын зардлыг зам барилгын ажилд шууд зардлын дүнгээс 2 хувиар, засварын ажилд шууд зардлын дүнгээс 4 хувиар тооцож төсөвт тусгана. Авто зам, замын байгууламжийн зураг төслийн Зохиогчийн хяналтын зардал нь Захиалагчийн хяналтын зардалд багтсан болно.
 - 5.4.6. Техник, технологийн хяналтын (Зөвлөх үйлчилгээ) зардал, Захиалагчийн хяналтын зардал, зураг төсөл Зохиогчийн хяналтын зардлыг тухайн объектыг шинээр барих, эсвэл засварлах зэргээс хамааруулан Захиалагч шийдвэрлэнэ.
 - 5.4.7. Зам барилгын ажилд ногдуулах НӨАТ-ын хэмжээг Монгол Улсын “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль”-ийн 11-р зүйлийн 11-1-д заасны дагуу барилга угсралтын ажлын төсвийн дүнгээс 10 хувиар тооцож нэгдсэн төсөвт тусгана.
 - 5.4.8. Авто замын барилга, засварын ажилд барилга угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгээс 0.4 хувиар шимтгэл тооцон нэгдсэн төсвийн тооцоонд тусгаж, норм нормативийн санд төвлөрүүлнэ.
 - 5.4.9. Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлтийн ажлын төрөл, тоо хэмжээг тогтоохын тулд хийгдэх техник ашиглалтын түвшин тогтоох ажлыг захиалагч байгууллага өөрийн хөрөнгөөр хийх ба тусад нь норм гаргаж үнэлгээг тогтооно.

ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТӨСВИЙН ТООЦООНЫ МАЯГТ БА ХАВСРАЛТ

ҮНДСЭН ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Маягт №3-1

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ	Ажилчдын мэргэжлийн зэрэг	Нэгж хөдөлмөр зарцуулалт хүн.цаг	Бүгд хөдөлмөр зарцуулалт хүн.цаг	Цалингийн тариф, ₮	Бүгд цалин, ₮	Нэмэгдэл цалин, ₮	Нийт цалин, ₮
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
									[8]*[9]		[10]+[11]
		Бүгд дүн									

МАТЕРИАЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Маягт №3-3

№	Үндэслэл	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Материалын орц		Материалын үнэ, ₮	
					Нэгж	Бүгд	Нэгж	Бүгд
1	2	3	4	5	6	7	8	9
						[5]*[6]		[7]*[8]
Материалын дүн								

ТЭЭВРИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Маягт №3-4

№	Материалын нэр	х/н	Материалын нийт орц	Нэгж хүнд, тн	Бүх жин, тн	Ачааны зэрэг	Тээвэр		Сийрэгжилтийн коэф.	Нийт жин, тн	Нийт зардал, ₮	Тээврийн хөдөлмөр зарцуулалт
							Зай	Тариф				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
	Нийт дүн											
	Цалингийн зардал 8,7%											
	Цалингийн зардал хассан дүн											

**МАШИН МЕХАНИЗМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТ
(МАШИН.ЦАГ)-ЫН ЗАРДАЛ**

Маягт №3-5

№	Үндэслэл	Машин механизмын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Машин цагийн тооцоо		Машин механизмын зардал, ₮	
					Нэгж	Бүгд	Нэгж	Бүгд
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн								
Цалингийн зардал 8,7%								
Цалингийн зардал хассан дүн								

НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ЗАРДАЛ

Маягт №3-6

№	Механизмын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж хүнд, тн	Нийт хүнд, тн	Зай, км	1тн/км тариф, ₮	Бүгд зардал, ₮	Хөдөлмөр зарцуулалт хүн.цаг
1	2	3	4	5	6	7	8	9	10
	Нийт дүн								
	Цалингийн зардал 8,7%								
	Цалингийн зардал хассан дүн								

АЖИЛЧДЫГ ТЭЭВЭРЛЭХ ЗАРДАЛ

Маягт №3-7

№	Ажилтан	Хэмжих нэгж	Хүний тоо	Зай, км	Тариф, ₮	Бүгд зардал, ₮
1	2	3	4	5	6	7
	Дүн					

ОБЪЕКТЫН ТӨСӨВ

Маягт №3-8

№	Зам барилгын ажлын төрөл	Нийт зардал, төгрөг	Үүнээс:													
			Цалингийн сан, сангаас тооцох НДШ							НДШ	Материалын зардал	Тээвэр		Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал	Ажлын хувцас, багаж хэрэгслийн элэгдлийн зардал	Түр барилгын элэгдэл
			Ажилчдын цалин	Нэмэгдэл цалин	ИТА-ийн цалин	Тээвэрчдийн цалин	Машин механизмчдын цалин	Нүүлгэн шилжүүлэлтийн тээвэрчдийн цалин	Материалын			Нүүлгэн шилжүүлэлт				
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	

БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ТӨСВИЙН ТООЦОО

Маягт №4-1

№	Зардлын нэр	Бүгд өртөг (төгрөг)
1	Ажилчдын цалин	
2	Тээврийн жолоочийн цалин - 8,7%	
3	Машин механизмын операторчдын цалин - 8,7%	
4	Нүүлгэн шилжүүлэх ажлын цалин - 8,7%	
5	Ажилчдын нэмэгдэл цалин - 15,1%	
6	ИТА-гийн цалин - 17%	
7	НИЙТ ЦАЛИН	
8	Нийгмийн даатгалын шимтгэл - 14%	
9	Материалын зардал	
10	Тээврийн зардал	
11	Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал	
12	Ажлын хувцас, багаж хэрэгслийн элэгдлийн зардал – 11,1%	
13	Түр барилгын элэгдэл	
14	Нүүлгэн шилжүүлэх зардал	
15	ШУУД ЗАРДЛЫН ДҮН	
16	Удирдлагын зардал – 63,5%	
17	Ашиг – 71,8%	
18	ХАБЭА-н үйл ажиллагааны зардал – 2,5%	
19	Ажиллагсдын даатгал	
20	Машин механизм, тоног төхөөрөмжийн даатгал	
21	Барилга угсралтын даатгал	
22	Ажилчдын хээрийн нэмэгдэл	
23	БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ТӨСВИЙН ДҮН	

Тайлбар:

Тээврийн зардал, машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал, нүүлгэн шилжүүлэх зардлаас цалингийн санд тооцсон 8,7%-ийг тус тус хасч тооцно.

НЭГДСЭН ТӨСВИЙН ТООЦОО

Маягт №5-1

№	Зардлын нэр	Бүгд өртөг (төгрөг)	Тайлбар
1	Ажилчдын цалин		Төсвийн цалингаас
2	Тээврийн жолоочийн цалин		Тээврийн зардлын дүнгээс 8,7%
3	Машин механизмын операторчны цалин		Машин механизмын зардлын дүнгээс 8,7%
4	Нүүлгэн шилжүүлэх ажлын цалин		Нүүлгэн шилжүүлэх зардлын дүнгээс 8,7%
5	Ажилчдын нэмэгдэл цалин		[1]+[2]+[3]+[4]-ийн нийлбэр дүнгээс 15,1%
6	ИТА-гийн цалин		[1]+[2]+[3]-ын нийлбэр дүнгээс 17,0%
7	НИЙТ ЦАЛИН		[1]+[2]+[3]+[4]+[5]+[6]-ын нийлбэр дүн
8	Нийгмийн даатгалын шимтгэл		[7]-ын дүнгээс 14%
9	Материалын зардал		Төсвийн материалын тооцоо
10	Тээврийн зардал		[Төсвийн цалин хассан тээврийн тооцооны дүнгээс]-[2]
11	Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал		[Төсвийн цалин хассан механизмын тооцооны дүнгээс]-[3]
12	Ажлын хувцас, багаж, хэрэгслийн элэгдлийн зардал		[7]-ийн дүнгээс 11,1%
13	Түр барилгын элэгдэл		Тусгай тооцоогоор
14	Нүүлгэн шилжүүлэх зардал		[Нүүлгэн шилжүүлэх зардлын дүн] – [4]
15	Ажилчдын хээрийн нэмэгдэл		Нийт хөд.зарц х 7200 төгрөг
16	ШУУД ЗАРДЛЫН ДҮН		[7]+[8]+[9]+[10]+[11]+[12]+[13]+[14]-ийн дүн
17	Удирдлагын зардал 63,5%		[7]-гийн дүнгээс 63,5%
18	Ашиг 71,8%		[7]-гийн дүнгээс 71,8%
19	ХАБЭА-н үйл ажиллагааны зардал 2.5%		[16]-ийн дүнгээс 2,5%
20	Ажиллагсдын даатгал 0.8%		Нэг хүний үнэлгээнээс 0.8 хувиар тооцно.
21	Барилга угсралтын даатгал – 0,4%		[16]-ийн дүнгээс 0.4 хувиар тооцно.
22	Машин механизм, тоног төхөөрөмжийн даатгал 0.5%		Балансын үнийн 0.5 хувиар тооцно.
23	БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ДҮН		[16]+[17]+[18]+[19]+[20]+[21]+[22]-ын нийлбэр дүн
24	Техник технологийн хяналт (Зөвлөх үйлчилгээний зардал)		[16]-ийн дүнгээс хүртэл * [5хувь хүртэл]
25	Захиалагчийн хяналтын зардал 2%		[16]-ийн дүнгээс 2%
26	Магадлашгүй ажлын зардал 2%		[16]-ын дүнгээс 2%
27	Өдрөөр тооцох ажил		Тооцоогоор
28	Нэмэгдсэн өртгийн албан татвар 10%		[23]-ын дүнгээс 10%
29	Норм, нормативийн сангийн шимтгэл 0.4%		[23]-ын дүнгээс 0,4%
30	ТАТ-ын зардал		Тооцоогоор

31	НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ	[23]+[24]+[25]+[26]+[27]+[28]+[29]+[30]-ийн нийлбэр дүн
----	-------------------	--

Тайлбар:

Тээврийн зардал, машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардал, нүүлгэн шилжүүлэх зардлаас цалингийн санд тооцсон 8,7%-ийг тус тус хасч тооцно.

Засвар арчлалтын ажилд захиалагчийн хяналтын зардлыг 4%-иар тооцно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ

Маягт №5-2

Ажил зардлын нэр ба зардал	Технологийн бүтэц				
	Барилга угсралт	Тоног төхөөрөмж		Бусад	Дүн
		Угсралт	Өртөг		
А	Б	В	Г	Д	Е
I БҮЛЭГ. БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ТӨСӨВТ ЗАРДАЛ					
Зам, замын байгууламжийн барилгын ажил	+	+	+		+
Бусад ажлын зардал	+	+	+		+
I бүлгийн дүн					+
II БҮЛЭГ. ТУСГАЙ ТӨРЛИЙН АЖИЛ БА ЗАРДАЛ					
Газрын төлбөр				+	+
Замын зурваст орсон барилга, инженерийн байгууламжийг нүүлгэн шилжүүлэх				+	+
Хөнгөлөлт, эсвэл нэмэлт төлбөртэй холбоотой зардал				+	+
Нөхөх төлбөр				+	+
II бүлгийн дүн					+
III БҮЛЭГ. ХАЙГУУЛ, ЗУРАГ ТӨСЛИЙН ЗАРДАЛ					
Инженерийн эрэл хайгуул, хэмжилт, инженер-геологийн судалгааны ажлын зардал				+	+
Зураг төслийн зардал				+	+
Зураг төсөлд магадлал хийх зардал				+	+
III бүлгийн дүн					+
IV БҮЛЭГ. БУСАД ЗАРДАЛ					
Зөвлөх үйлчилгээний зардал				+	+
Захиалагчийн хяналтын зардал 2%				+	+
Магадлашгүй ажлын зардал 2%				+	+
Өдрөөр тооцох ажил	+		+	+	+
Нэмэгдсэн өртгийн албан татвар 10%	+		+	+	+
Норм, нормативийн сангийн шимтгэл 0,4%				+	+
IV бүлгийн дүн					+
Технологийн бүтцээр ангилсан хэсгийн дүн	+		+	+	+
НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭМЖЭЭ				I+II+III+IV	

Хавсралт 3-1

**ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ТӨСӨВ БОДОХОД ХЭРЭГЛЭХ АЖИЛЧДЫН
ЦАГИЙН ТАРИФТ ЦАЛИНГИЙН ЖИШИГ**

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт		Мэргэжлийн зэрэг					
	Тарифын итгэлцүүр		I	II	III	IV	V	VI
			1.00	1.11	1.25	1.44	1.66	1.92
1	Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажилладаг	Цагаар хөлс авагчид	3764	4177	4705	5421	6248	7225
2		Хийснээр хөлс авагчид	4165	4623	5207	5998	6915	7997

Хавсралт 3-3

ЗАМ БАРИЛГЫН АЧААНЫ АНГИЛАЛ

II зэргийн ачаа	III зэргийн ачаа
Даацанд хүргэхийн тулд давхарлан ачих боломжгүй материал, лааз савтай тосон болон шороон будаг, лак, олиф	Барилгын дулаалгын шингэн хөвөн, хөөсөнцөр
Савтай болон автоцистернтэй шингэн спирт, глицерин, битум, асфальт бетон хольц, уусгагч бодисууд	Чийдэнгийн шил
Хүрмэн чулуу, перлит, керамкит	Модны үртэс, зоргодос
Асбестон хоолой	Сүрэл
Хөнгөнбетон хийц	Уурын зуухны үнс
Хуудсан төмрөөр хийсэн агаар дамжуулах хоолой, салхивчийн бусад эдлэлүүд	Уурын тогоо
Керамзит, гипс, хөнгөнбетон, үнс, модны үртэс, зоргодос гэх мэт материалаар хийсэн хамар хана, бамбай, зулавч хавтан	Бойлер
Рубероид, толь, пергамин, гидроизол, изоль, шалны хулдаас, ханын цаас	Ферм, түүний холбоос
Хавиргат хавтан, ханын хавтгаалж, шатны марш, худгийн цагираг, онгоц гэх мэт овор хэмжээ ихтэй төмөрбетон эдлэл	Бункер, циклон
Өндөр хүчдэл, холбооны агаарын шугмын 6м-ээс урт шон	Төрөл бүрийн ёмкость, бак
Барилгын хаалга, цонх	Төрөл бүрийн яндан хоолой
Төрөл бүрийн кабель, утас	500 мм-ээс дээш голчтой утааны яндан
Сантехник, цахилгааны зарим тоноглол, хэрэгсэл	
Гэрлийн бүрхүүл	

Жич: Энэ жагсаалтад ороогүй ачааг I зэргийн ачаа гэж үзнэ.

АВТОМАШИНААР АЧАА ТЭЭВЭРЛЭХ 1ТН.КМ-ЫН ЖИШИГ ТАРИФ

Тээврийн зай км-ээр	Ачааны зэрэг		
	I	II	III
1	960.47	1272.78	1699.11
2	621.48	838.56	1074.01
3	516.48	691.21	925.58
4	478.4	635.53	851.36
5	453.71	583.93	785.9
6	415.61	546.18	732.15
7	376.64	495.86	663.48
8	373.4	492.65	656.86
9	366.48	486.25	648.33
10	348.9	461.73	619.12
11.-15	334.65	444.24	591.18
16-20	323.62	429.95	571.79
21-25	314.1	415.02	553.86
26-30	296.55	392.84	524.64
31-40	281.83	375.49	497.34
41-50	271.67	358.94	477.72
51-60	261.49	346.55	460.03
61-70	251.1	331.84	440.61
71-80	240.7	317.77	422.27
81-90	229.88	304.34	403.91
91-100	219.71	290.47	395.19
101-ээс дээш	216.56	280.66	391.34

Энэхүү тариф Зам, тээврийн сайдын 2013 оны 162 дугаар тушаалаар баталгаажсан.

ХОТ ХООРОНДЫН ЗОРЧИГЧ ТЭЭВРИЙН 1ХҮН.КМ-ИЙН ЖИШИГ ТАРИФ

Үзүүлэлт	Зорчигч тээврийн хэрэгсэл	
	Том болон дунд оврын	Бага оврын
1хүн.км-ын жишиг тариф	45-55	55-65
Тайлбар:		

ЗАМЫН МАШИН МЕХАНИЗМЫН АШИГЛАЛТЫН ЦАГИЙН ЖИШИГ ҮНЭ

Тайлбар: Замын машин механизмын ашиглалтын цагийн жишиг үнийг баталсаны дараа оруулна.

ГАРЧИГ

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ		03
НЭГ.	ҮНДСЭН ХЭСЭГ	
1.	АВТО ЗАМЫН САЛБАРЫН ҮНЭ БҮРДЭЛТИЙН СИСТЕМИЙН НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	04 - 05
2.	ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН АЖЛЫН ТӨСӨВ БОДОХ АРГАЧЛАЛ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ТӨСВИЙН БАРИМТ БИЧГИЙН БҮТЭЦ	05 –06
3.	ОБЪЕКТЫН ТӨСВИЙН ТООЦОО	
3.1.	Ерөнхий зүйл	07 – 08
3.2.	Ажилчдын болон ИТА-ын хөдөлмөр зарцуулалт, цалингийн зардлын тооцоо	08
3.3.	Зам барилгын ажлын материалын болон тээврийн зардлын тооцоо	09 – 10
3.4.	Зам барилгын ажлын машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлын тооцоо	10
3.5.	Нүүлгэн шилжүүлэх зардлын тооцоо	10 – 11
3.6.	Зам барилгын ажлын багаж хэрэгсэл, ажлын тусгай хувцас, түр барилгын элэгдлийн тооцоо	11
3.7.	Зам барилгын ажил гүйцэтгэх ИТА, зам барилгын ажилчдын нийгмийн даатгалын шимтгэл /НДШ/-ийн зардлын тооцоо	11
4.	БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ТӨСВИЙН ТООЦОО	
4.1.	Ерөнхий зүйл	12
4.2.	Удирдлагын зардлын тооцоо	12
4.3.	Ашгийн тооцоо	13
4.4.	Төсөвт тусгах даатгал болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны зардлын тооцоо	13–14
4.5.	Зам барилгын ажилчдын хээрийн нэмэгдлийн тооцоо	14
5.	НЭГДСЭН ТӨСВИЙН ТООЦОО	
5.1.	Ерөнхий зүйл	15
5.2.	Тусгай төрлийн ажил ба зардлын тооцоо	15
5.3.	Хайгуул, зураг төслийн зардлын тооцоо	15
5.4.	Нэгдсэн төсвийн тооцоонд орох зардлын тооцоо	15 – 16

ХОЁР.	ТӨСВИЙН ТООЦООНЫ МАЯГТ БА ХАВСРАЛТУУД	
	Маягт №3-1: Ажилчдын хөдөлмөр зарцуулалт, цалингийн тооцоо	17
	Маягт №3-3: Материалын зардлын тооцоо	18
	Маягт №3-4: Тээврийн зардлын тооцоо	19
	Маягт №3-5: Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт (машин.цаг)-ын зардал	20
	Маягт №3-6: Нүүлгэн шилжүүлэх зардал	21
	Маягт №3-7: Ажилчдыг тээвэрлэх зардал	21
	Маягт №3-8: Объектын төсөв	22
	Маягт №4-1: Барилга угсралтын ажлын төсвийн тооцоо	23
	Маягт №5-1: Нэгдсэн төсвийн тооцоо	24-25
	Маягт №5-2: Хөрөнгө оруулалтын хэмжээ	26
	Хавсралт 3-1: Зам, замын байгууламжийн төсөв бодоход хэрэглэх ажилчдын цагийн тарифт цалингийн жишиг	27
	Хавсралт 3-3: Зам барилгын ачааны ангилал	28
	Хавсралт 3-4: Автомашинаар ачаа тээвэрлэх 1тн.км-ын тариф	29
	Хавсралт 3-5: Хот хоорондын зорчигч тээврийн 1 хүн.км-ийн жишиг тариф	30
	Хавсралт 3-6: Замын машин механизмын ашиглалтын цагийн жишиг үнэ	30